



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



М О Д




ТАРИХ ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот 2017



МОД ТАРИХЫН АЧ ХОЛБОГДОЛ:


НЭГ ГА ойн мод сөөг нь **18 сая** шоо метр агаарыг цэвэршүүлж, утаа униарын **30-35** хувийг өөртөө шингээдэг. Ялангуяа навчит мод дуу чимээний **25** хувийг замхруулж, тоос шороог **21-76** хувь хүртэл өөртөө барьдаг байна.



Ой мод нүүрсхүчлийн хийг шингээж, хүчилтөрөгчийг үйлдвэрлэдэг. Гэхдээ энэ нь ой болгон дээр харилцан адилгүй. Жишээ нь халуун орны ой жилийн дөрвөн улиралтай газрын ой моддоос хэдэн хувь илүү түргэн өсөж ургадаг. Тэр ч утгаараа халуун орны ой яг адилхан хугацаанд илүү их хэмжээний нүүрсхүчлийн хийг шингээдэг гэсэг үг юм.


Хаврын тариалалт **04.25–аас 06.01**-ны хооронд буюу газар гэссэний дараа, нахиа задраагүй байх үед.

Намрын тариалалт **09.25–аас 11.01**-ны хооронд буюу газар хөлдөхөөс өмнө.



Тарьц гэж мод үржүүлгийн газарт үр болон мөчрөөр ургуулсан 1-2 настай модлог ургамлын хэлнэ. Харин суулгац гэж бойжуулгын талбайд шилжүүлэн суулгаж ургуулсан 2-оос дээш настай модлог ургамлыг хэлнэ. Мод таригчдад өөрийн орны нөхцөлд ургах чадвар бүхий, мод үржүүлгийн газарт үрээр ургуулсан 2-4 настай суулгацыг сонгож авахыг зөвлөдөг.






МОД СУУЛГАХАД ХЭРЭГЛЭГДЭХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ:

- Хүрз
- Жоотуу
- Тармуур
- Шороо зөөх тэрэг
- Хувин
- Шланк
- Хэмжих метр



МОД ТАРИХ ХЯЛБАРШУУЛСАН АРГАЧЛАЛ



5

10 сард цэнэг
усалгааг ханатал
хийнэ. Усалгааг
хийх явцад хөрсний
сийрүүлэлт хийх



Оройн цагаар 7-10 хоногт
40-50л усаар нэг модыг 1-2
удаа усална.

Өглөө услахад
өдрийн турш
усалсан усаа, бас
дээр нь өөрийн
чийгээ алддаг
тул зөвхөн орой
усална.

6

3 жилийн
дараагаас үндэс нь
гүний усанд хүрдэг
тул арчилгаа усалгааг
хийх шаардлагагүй
болно



УЛИАС

Улиас нь бургасны овогт хамаарна. Улиас нь фитонцид хэмээх агаарыг цэвэршүүлдэг бодисыг агуулж байдаг тул хот сууринд өргөн хэмжээгээр тарьж ургуулдаг. Ихэвчлэн нэг гэрт ургамал ба хааяа хоёр гэртэй байх нь тохиолддог. Улаанбаатар хотод хавар эрт навчлахаас өмнө V сарын эхний 15 хоногт эр цэцгийн нахиа задардаг. VI сарын эхний 10 хоногт навчилна. Харин говьд улиасны нахиа IV сарын 20-ноос хөөнө. VII сарын эхний 10 хоногт эм цэцэг нь боловсорч үр нь хөвөн шиг цагаан зүйлийн хамт салхинд хийсч тархана. Уг үрийг харшил үүсгэгч гэж үздэг талтай.

Монголд 5 зүйлийн улиас ургадаг.


1. Тоорой (*P.diversifolia* Schrenk)
2. Улиангар (*P.tremula* L.)
3. Лавар навчит улиас (*P.laurifolia* Lab.)
4. Үслэг улиас (*P.Pilosia* Rehder)
5. Анхилуун улиас (*P.Densa* kom)




УРГУУЛАХ АРГА, АРЧИЛГАА:

Улиасыг ихэвчлэн мөчрөөр, тайрдсаар үржүүлнэ. Мөчрийг ургамал тайван байх 3 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 10-н хүртэл хугацаанд бэлтгэнэ. Нэг настай 0.5-1 см бүдүүн мөчрөөс 0.8-1 метр хүртэл урттай савааг бэлтгэн 50 юм уу 100-аар боож нойтон элсэнд хадгална. Хавар тарихаас өмнө 20-22 см-ийн урттайгаар оройн нахиаг гэмтээхгүйгээр жижиг тайрдас бэлтгэнэ.

Мөчир тарих хөрсийг 30-40 см гүнтэйгээр хагалж борнойдоод 3x4 метр хэмжээтэй жижиг дэвсэг хийж сайтар услаад нэг юмуу хоёр өдөр өнжүүлээд бэлтгэсэн мөчрөө өөр хооронд нь 30см, эгнээ хооронд нь 40см-ийн зайтайгаар хүрз эсвэл колесовын царилаар суулгана. Улиас үрээр соёолж ургахад боломжтой боловч нялх цухуйц нь арчилгаа тордолт их шаарддаг, биежиж бойжихдоо удаан тул үрээр ургуулах нь нэн ховор.





Улиасны мөчрийн тайрдсыг 3 дугаар сарын 10-аас 20-ныг хүртэлх хугацаанд бэлтгэдэг. Энэ үед нахиа хөөгөөгүй байдаг сайн талтай. Улиасны мөчрийн тайрдсыг хоёр аргаар тарьж ургуулдаг.


1. НАХИА ХӨӨЖ ЗАДРААГҮЙ УРГАМАЛ ТАЙВАН БАЙХ ҮЕД НЬ БЭЛТГЭДЭГ ЕРӨНХИЙ АРГА. Энэ нь 4-5 нахиатай оройн нахианы орчим ташуу, ёроолын хэсгийг эгц хайчлах нь зохимжтой ёроолын тэгш тайрсан хэсэгт каллюс буюу үндэс бөөгнөрч жигд ургадаг сайн талтай.
2. Мөчрийн оройн хэсэгт 5-10 см урт найлзууртай тэдгээрийн нахиа хөөж, томорсон эсвэл нахиа бага зэрэг задарч навчны үзүүр цухуйсан мөчрөөс 20-22 см урттайгаар бэлтгэн боловсруулсан талбайд мөн 30x30 см-ийн урттай шуудуунд тарих нь илүү тохиромжтой.

Урт шуудуунд тарих нь мөчир жигд сайтар ургах бөгөөд 2 см-ийн дусалтай 13 мм шланкаар тодорхой давтамжтай услахад тохиромжтой байдаг. Мөчир суулгасан талбайгаа суваг шуудуугаар халиан услана. Цаашдаа эхний үед 7 хоногт 2 удаа, найлзуур нь задарч жигд соёолсон үед усалтыг цөөрүүлэх шаардлагатай. Мөн зэрлэг ургамлыг илэрсэн тухай бүрд үндсээр нь зулгааж цэвэрлэнэ. Үүний зэрэгцээ шавранцар хөрсөнд тарьсан мөчрийн мөр, эгнээ хоорондох хөрсийг сийрүүлэх нь чухал.



ХАЙЛААС

Монгол оронд том үрт болон тарваган хайлаас гэсэн зүйл ургана. 5-10 метр хүртэл өндөр ургадаг том мод буюу сөөг юм. Залуу мөчир найлзуур нь шар холтостой, навчны нахиа мохоо, өндгөрхүү, арьслаг зузаан юүлд хэлбэртэй, навч нь жижгэвтэр бөгөөд ирмэг нь хөрөөн шүдлэгтэй, навчны голоос хоёр тийш гарсан тэгш хэмт тод хээтэй.



Ургалт нь V сарын эхээс IX сарын сүүл хүртэл үргэлжилнэ. Хэлбэржилт сайн даадаг. Манай орны говь цөл хуурай хээр талд тархан ургасан, амьдрах чадвар сайтай, өсөлт хурдан ган болон хүйтэнд тэсвэртэй.




УРГУУЛАХ АРГА, АРЧИЛГАА:

Үрээр үржүүлнэ. Үр нь хавар 5 дугаар сарын сүүлээр боловсорч маш богино хугацаанд унадаг. Иймд үрийг түүгээд шууд тарих бололцоотой. Үрээ тарихын өмнө 1-2 цаг чийглэн дэвтээсний дараа тарина.

Нэг га-д цэвэр үр дунджаар 120 кг ноогдохоор бодож далавчтай нь тарина. 0.5-1 см гүнд үртэс ба хөнгөн хөрсөөр хучиж тарина. 2-3 настай тарьцыг бойжуулах болон ойжуулалт, цэцэрлэгжүүлэх ажилд шилжүүлэн суулгана.

Үрийг бага даралттай усаар шүршиж жигд соёолуулна. Соёолсны дараа шуудуугаар услана. 5-7 хоногт тогтмол услах ба хур бороо элбэг үед услах шаардлагагүй болно.

Хөрсийг 7 хоногт нэг удаа сийрүүлнэ. Хог ургамлыг тогтмол зулгааж зайлуулна. Хоёр настайгаас нь суулгачын доод хэсгийн найлзуурыг таслан авч гол ишийг гаргах замаар хэлбэржүүлэхэд анхаарах хэрэгтэй. Хэлбэржүүлэлтийг жил бүр тогтмол хийвэл хайлаас өндрөөшөө түргэн өсдөг тул буталж ургахыг зогсоодог сайн талтай.



БУЙЛС

Монгол буйлс нь Говь-Алтай ба Алашаагийн говиор уул толгодын хад чулуутай энгэр, сайрыг дагаж ургадаг бол бариулт буйлс нь Хэнтий, Хангай, Монгол-Дагуур, Монгол-Алтай зэрэг газруудаар уул толгодын хад чулуутай энгэр, судаг сайрын хажуу ёроол, хээрийн элс, түүний захаар тархан ургадаг.

Мөчир өргөсгүй, навч нь эсрэг өндгөн юмуу уртавтар зуван хэлбэртэй, 2-3 см урттай, навчны зах хурц хөөрөн шүдлэг цэцэг нь тод ягаан өнгөтэй, жимс нь жижиг ишинцэр дээр байрлах бөгөөд 4-8 мм голчтой.

Улаан саарал холтос бүхий богиноссон хатгуур, өргөс бүхий мөчиртэй шим тэжээлийн бодис багаар шаарддаг бөгөөд, хөрс хамгаалах ач холбогдолтой ургамал юм. Хавар навчлахаасаа өмнө цэцэглэдэг, цагаан, ягаан том цэцэгтэй. Монголчууд буйлсийг Японы Сазуро гэж ярьдаг. Харамсалтай нь үзэсгэлэнт сайхан цэцэгтэй байх хугацаа нь 7-10 хоногоос хэтэрдэггүй.

УРГУУЛАХ АРГА, АРЧИЛГАА:

Үрээр сайн ургана. Үрийг намар юмуу хавар тарьж болно. Үрийг 30-50 хоног эртжүүлэлт хийнэ. Нэг уртааш метр газарт 30-40 грамм үр орно. Үр тарих гүн гурав хүртэл см байвал зохистой.

Харин VII сарын сүүлийн 10 хоногт монгол буйлсны үр боловсордог бөгөөд бариулт буйлсийг бодвол том үртэй. Ер нь монгол буйлс 1.5 метрээс 2 метр өндөр ургадаг. Говь нутагтаа үрээр ургахад сайн байдаг. Үрээр ургасан суулгацыг шилжүүлэхэд тэдгээрийн амьдралт бусад мод сөөг ургамлаас доогуур байдаг. Цаашдаа цэцэрлэгжүүлэлт, ойжуулах ажилд шууд үрээр тарих нь зүйтэй.

Харин шилжүүлсэн суулгац нөхөн сэргэхдээ удаашралтай байдаг. Нэг наст буйлс 15.2 см өндөр 0.2 мм диаметртэй, 3 настай нь 72.6 см өндөр 7.4 мм диаметртэй.

Усалгаа тарилтын эхэн үед 7 хоногт 2 удаа бөгөөд жигд цухуйсан үед суваг шуудуугаар услана. Хог ургамлыг тогтмол устгана. Сийрүүлэлтийг хөрсний хэв шинжээс хамаарч янз бүр хийнэ.



Улаанбаатар хотод
цэцэглэсэн бут

Буйлс нь хөрс голдоггүй ямарч хөрсөнд сайн ургадаг онцлогтой. Усалгаа бага шаардана. Буйлсны 3-4 настай суулгацыг цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, амьд хашаанд, бусад мод, сөөгтэй хослон тарихад тохиромжтой. Мөн элсний нүүлт зогсоох, хөрс хамгаалахад ашиглаж болно. Ургал эрхтэнээр үрждэггүй онцлогтой.




ШАР ХУАЙС

Манай орны Хөвсгөл, Хангайн өндөр уулын ам хавцалд зэрлэгээр ургана. Голын эрэг, чулуутай хажуу, шинэсэн ой түүний захар ургадаг модлог бут юм. Хот суурин газар их тарьдаг. Хөнгөндүү элсэрхэг хайргатай чийглэг, шим тэжээл сайтай ургамал.

Залуу мөчрийн навч найлзуур нь малын тэжээл болдог. Олон наст 2-5 метр өндөр ургадаг модлог сөөгөн, балт ургамал. Иш нь ногоондуу туяатай, шаргалдуу холтстой, 4-7 хос навчинцраас бүрдэх нийлмэл навчистай.

Урт өргөнөөрөө тэнцүү шахам цомирлогийн шүдлэг нь жижигхэн. Үрийн буурцаг бортгорхуу, буурцагийн хонхорцог нь үр боловсрох үедээ салж хүчтэй хуйлран эргэлддэгээс үр нь замбараагүй цацагддаг.

Говьд шархуйсны нахиа IV сарын 10-наас хөөж IV сарын 20-нд навч нь цухуйж эхлэх боловч говийн бусад модноос нилээд сүүлд жигд цухуйдаг. Харин намар эрт шарладаг, өөрөөр хэлбэл V сарын дунд 10 хоногт шарлаж X сарын эхний 10 хоногт унах жишээтэй. Үр нь VII сарын хоёр дахь 10 хоногт боловсордог.



УРГУУЛАХ АРГА, АРЧИЛГАА:

Үрээр маш сайн ургана. Үрийг VII сарын сүүл VIII сарын эхээр түүнэ. Буурцаг арай задраагүй байхад түүж аваад дэлгэж хатааж авна. Үрийг ихэвчлэн хавар IV сарын сүүлийн 10 хоногт буюу V сарын эхний 10 хоногт багтаан тарина.

Үрийг нэг метр уртаашд 4 граммаар боддог боловч үрийн тарих норм нь тухай н жилийн үрийн ургацын байдал, чанараас их хамаарна.

Тарилтын өмнө буцалсан халуун усанд хийж 10-12 цаг дэвтээн хөөлгөнө. Үрийг 1-1.5 см хүртэл гүнд тарина.

Говийн нөхцөлд шархуйсны үрийг хүлэмжинд IV сарын дунд 10 хоногт, ил талбайд IV сарын сүүлчийн 10 хоногт тарих нь зохимжтой. Үрийг дэвсэг юмуу шуудуунд тарих нь сайн. Хэрвээ 13 мм-ийн диаметртай 20 см-ийн зайтай дуслын системтэй шуудуунд үр тарьсан тохиолдолд өдөр бүр усалж, үр соёолж биежсэн үеэс усалтыг цөөрүүлэх нь зүйтэй.


Шархуйсны мөчрийг бэлтгэх нь улиасны мөчрийн тайрдас бэлтгэхтэй адил. Говьд III сарын сүүлчийн 10 хоногт бэлтгээд нэг метр гүнтэй 0.8 см өргөн нүхэнд нойтон элсэн дээр бэлтгэсэн савааг 5-10 см-ийн зайтай хэвтүүлэн эгнүүлэн тавиад нойтон чийгтэй элсээр хучих замаар бүх савааг дарж нүхээ дүүргэсний дараа 30-40 см зузаан чийгтэй шороогоор дарах замаар IV сарын эхний 10 хоног хүртэл хадгалаад 30х30 см-ийн шуудуунд том чулуу, ургамлын үндэсгүй шороо бага зэрэг саарал бууцтай хольж хийнэ.

Уг шуудууг нэвтэртэл услаад, шингэсний дараа, дараагийн өдөр нь хөрс өлөн чийгтэй байхад 20 см-ийн хэмжээтэй бэлтгэсэн тайрдасыг эгнээ хооронд 25-30 см-ийн зайтайгаар суулгана. 7-10 хоногийн дараа хөрсөн дээр ил гарсан нахиа соёолж ургана. Шуудууны уртааш 20 см-ийн дусалтай 13 мм-ийн шланк тавьж усалдаг, соёололтонд сайн нөлөөлдөг болно. Нэг настайдаа 16.5 см өндөр 0.4 мм диаметр, 2 настай нь 89 см өндөр 0.9 мм диаметртай болж ургана.

Үрээр тарьсан 2-3 настай тарьцыг бойжуулах талбайд шилжүүлэн суулгаж хэлбэржүүлэх арчилгааг тогтмол хийнэ. Үүний дараа ногоон байгууламжинд амьд хашаа, хэсэг бүлгээр ганц ганцаар ургуулж болно.


Хөрс нь хөнгөн сийрэг байвал илүү сайн ургана. Усалгааг тарилтын дараа дөрвөн хоногт нэг удаа услаад, хойшид цөөрүүлнэ. Сийрүүлэлт сайн хийж өгөх ба хог ургамлыг үндсээр нь зулгааж устгах хэрэгтэй.





Шар хуайс нь цэцэрлэгжилтийн ажилд өргөн дэлгэр ашиглагддаг бут сөөг юм. Шар хуайсыг ихэнх тохиолдолд хамгаалах чиглэлээр ургамлан хашлаганд тарьдаг. Ингэж тарьж байгаа нь олон талын ач холбогдлыг агуулж байна. Үүнд:

1. Ногоон байгууламжаа хүн, мал амьтан, машин техникийн сөрөг нөлөөллөөс хамгаалж байна.
2. Бүтээн бий болгосон ногоо байгууламжаа , зам талбай болон бусад зүйлээс ялгаварлан зааглаж байна.
3. Ургамлан хашлагыг ямарч байдлаар засч хэлбэржүүлж, гадаад өнгө үзэмжийг сайжруулж болдог сайн талтай.



ӨРГӨСТ НОХОЙН ХОШУУ

Туяхан иштэй сөөг юм. Иш мөчир, найлзуур, навчны бариул хүртэл өргөстэй. 3-10 см урт хос бус өдлөг нийлмэл навчтай өндгөрхүү юмуу зуувгар, хурц орой бүхий 5-7 навчинцараас бүрдэнэ. Навчинцар цайвар ногоон өнгөтэй, нүцгэн гадаргатай. Голчоороо 3-5 см ягаан хүрэн, улаан өнгийн 5-7 дэлбээ бүхий цэцэгтэй.

Өргөст нохойн хошуу нь байгальд ихэвчлэн шинэс, нарс, хусан ойн дунд ургах бөгөөд 80 см-аас 1.5 метр орчим өндөр болно.

УРГУУЛАХ АРГА, АРЧИЛГАА:

Үрээр маш хурдан ургадаг онцлогтой. Үрийг намар түүж шууд тарих буюу хавар тарьдаг.

Үрээр тарьсан 2-3 настай тарьцыг бойжуулах талбайд шилжүүлэн ургуулж 2-3 жил болгосны дараа цэцэрлэгжүүлэлтэнд ашиглана. Цэцэрлэгжүүлэлтийн ногооруулах ажилд амьд хашаа болон бусад мод сөөгтэй хослон бүлгээр тарихад тохиромжтой хэлбэржүүлэлт маш сайн даадаг онцлогтой.

Үрээс ургасан навтгар нохой хошууны нэг настай тарьц нь 31.6 см өндөр 0.6 мм диаметртэй, 2 дахь жилийн суулгац 66.6 см өндөр 0.8 мм диаметртэй, гурван настай нь 136 см өндөр 1.06 мм диаметртэй болж ургадаг.

Үрэнд маш их арчилгаа шаарддаг. Үрээ тарьсны дараа шүршүүрээр зөөлөн усалж жигд соёолуулах нь чухал. Соёолсон цухуйцыг суваг шуудуугаар усалж арчилгааг тогтмол хийх шаардлагатай байдаг.

